

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЦАЙ ВЭНЬРУЙГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт Г.Чулуунбаатар дэд ерөнхийлөгч өө!

Эрхэм хүндэт Д.Булган дарга аа!

Эрхэм хүндэт Д.Золбоо захирал аа!

Эрхэм анд нөхөд өө!

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж байна. «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийн 70 жилийн ойн эрдэм шинжилгээний хурлын ажиллагаанд оролцох завшаан тохиолдсонд нэн их баяртай байна. Энэхүү хэлэлцээр нь Хятад, Монголын харилцааны найрамдлын түүхэнд онцгой ач холбогдолтой. Мөн, Хятад, Монгол хоёр улсын хооронд үзэглэсэн анхны хэлэлцээр юм. Хоёр улсын эдийн засаг, соёлын харилцааны чухал бэлгэ тэмдэг билээ.

1952 оны 9 дүгээр сард, БНМАУ-ын Ерөнхий сайд Юмжаагийн Цэдэнбал тэргүүтэй төлөөлөгчид Хятад улсад айлчилсан. Энэ айлчлал бол шинэ Хятад улс байгуулагдсаны дараах анхны гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсоор Хятад улсад айлчилсан явдал байлаа. Хятадын тал ёслол төгөлдөр, халуун дотноор угтан авсан. Айлчлалаар талууд «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийг байгуулсан. Энэ хэлэлцээрт үндэслэн хоёр улс эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны сайхан харилцааг бий болгосон билээ. Ялангуяа, 1950, 60-аад онуудад, Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих үүднээс Хятад улс их хэмжээний техник технологи болон ажилчдыг томилон Монгол Улсад олон олон дэд бүтэц барьсан. Ингэснээр Монгол Улсын хөгжилд чухал туслалцаа үзүүлсэн. Улаанбаатарын Энхтайвны гүүр, Их дэлгүүр, Спортын ордон зэрэг бэлгэ тэмдэг болсон барилгуудыг одоо ч ашигласаар байна. Эд бол Хятад, Монголын найрамдлын баталгаа, хоёр улсын ард түмний нөхөрлөлийн бэлгэдэл юм.

Хятадын Засгийн газар Монгол Улстай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгдөг. Хятадын тал Монгол Улсад “элэгсэг дотно, үнэнч шударга, үр ашигтай, хүртээмжтэй” гадаад харилцааны үзлийг идэвхтэй баримталдаг. Цаашид ч мөн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бүх чадлаараа туслалцаа үзүүлэхэд бэлэн байна. Өдгөө, Хятад, Монгол хоёр улс Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, стратегийн энэ өндөр түвшний харилцаанд хүрээд байгааг харахад таатай байна. Хоёр улсын улс төр, эдийн засаг, соёл зэрэг бүхий л салбарын харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байна. Ялангуяа, өнгөрсөн жил хоёр улсын худалдааны эргэлт 10 тэрбум ам.долларыг давлаа. Хятад улс олон жилийн турш Монгол Улсын хамгийн том худалдааны түнш,

хамгийн чухал хөрөнгө оруулагч улс хэвээр байна. Энэ бүхэн дээрх хэлэлцээр хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд бат бэх суурь бий болгосонтой салшгүй холбоотой. Энэхүү хэлэлцээр нь мөн Хятад, Монголын "Хувь заяаны хамтын нэгдэл"-ийн агуулгыг улам бүр тодруулж харуулсан. Энэ онд хоёр улсын өндөр дээд түвшний харилцан айлчлал, харилцаа сайн хандлагаа хадгаллаа. Хоёр улсын удирдагчид эдийн засаг, соёл зэрэг хамтын ажиллагааны чиглэлээр чухал цуврал нэгдсэн ойлголцолд хүрсэн. Хятад, Монголын харилцаанд хөгжлийн сайхан боломж байгаад бид туйлын баяртай байна.

Эцэст нь, энэ үйл ажиллагааг сэтгэл гарган зохион байгуулж буй Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнд талархлаа илэрхийлье. Урт хугацааны турш Хятад, Монголын харилцааны хөгжилд санаа тавьж, дэмжиж, урагшлуулж ирсэн Монголын эрдэмтэн, судлаачид, анд нөхдөдөө талархлаа илэрхийлье. Та бүхэн энэхүү хэлэлцээрийг байгуулсан нөхцөл, ач холбогдол хийгээд Хятад, Монголын эдийн засаг, соёл, боловсрол зэрэг салбарын харилцааны түүхийн талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлэг хийх юм байна. Хэлэлцүүлэг гайхалтай сайхан болно гэдэгт итгэлтэй байна. Энэ удаагийн хуралд амжилт хүсье!